

“УУЛ УУРХАЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖ, ХЭРЭГЖИЛТ”

СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Ховд аймаг, Жаргалант
2019 оны 6 дугаар сарын 26-27-ны өдрүүд



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨГЛӨӨГЧ АГЕНТАТ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТООСНЫ ГАЗАР



СЕСМИМ
ТӨСӨЛ
МОНГОЛ УЛСЫН ӨЛБӨРЛӨХ САЛБАРЫН
МЭНЭГЭЭЛЭННИЙ БОЛОВУУЛАХ ТӨСӨЛ

СЭДЭВ:
“Уул уурхайн салбарын институц,
чадавхи, орон нутгийн түвшин дэх
салбар хоорондын уялдаа холбоо”

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны
Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын
ахлах мэргэжилтэн
Ч. ЦОГТБААТАР



УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ИНСТИТУЦ



УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ИНСТИТУЦ

- ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГА –УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

- ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА –АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

- ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ:
- ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ
- БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ



■ ЯАМНЫ ЭРХЭМ ЗОРИЛГО


- Ил тод, хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоход оршино.

■ ЯАМНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:

- Геологийн салбарын бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, геологийн судалгаа, ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
- Уул уурхайн салбарын бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож бүх төрлийн ашигт малтмалын олборлолт, баяжуулалт, борлуулалт, экспортын асуудлыг бодлогын удирдамжаар хангах замаар улс орны эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх;
- Хүнд үйлдвэрийн салбарын бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, тэргүүний технологи, инновацийг нэвтрүүлэх, нутагшуулах, шинэчлэх, замаар үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах, хөгжүүлэх;
- Түлш, газрын тосны салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож газрын тос, уламжлалт бус газрын тосны (нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар, тослог элс гэх мэт) эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлэх, олборлолт, борлуулалтыг тогтвортой урт хугацаанд хадгалаж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх, газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, түлшний чанар, стандартыг сайжруулж, агаарын бохирдлыг бууруулах;
- Геологи, уул уурхай, түлш, хүнд үйлдвэрийн салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхийг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах;
- Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх;
- Геологи, уул уурхай, газрын тос, түлш, хүнд үйлдвэрийн салбарт техникийн шинэчлэлт хийж, байгаль орчинд хал багатай, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;
- Иргэний нийгмийн оролцоонд суурилсан ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга” болон “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга”, тэдгээрийн зарчмууд болон стандартыг нэвтрүүлэх;
- Геологи, уул уурхай, газрын тос, түлш, хүнд үйлдвэрийн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд анхаарч ажиллах;



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ БҮТЭЦ



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

▪ АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ЭРХЭМ ЗОРИЛГО

- Төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.


• АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах;
- хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасан төлөвлөгөө, тайлан, хайгуулын ажлын зардлын доод хэмжээний талаар хяналт тавих;
- ашигт малтмалын тойм судалгаа хийх хүсэлтийг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх;
- уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа техник, технологид үнэлэлт, дүгнэлт өгөх, техник, технологийн бодлогыг хэрэгжүүлэх;
- уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, тухайн үед үүссэн нөхцөл байдалд үнэлэлт өгөх;
- уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны эдийн засаг, нийгмийн салбарт үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах;
- уул уурхайн бүтээгдэхүүний үнийг судлах, эрэлт, хэрэгцээ, хэтийн төлвийг тодорхойлох;
- уул уурхайн үйлдвэрлэлийн тодорхой төслийг хэрэгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, хэрэгжүүлэх;
- тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргах;

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

- АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:
 - хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих;
 - ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох, цуцлах, шилжүүлэх, барьцаалах, талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх, шилжүүлэх ажиллагааг олон нийтийн хяналтын дор явуулах нөхцөлийг бүрдүүлэх;
 - ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг өргөдлийг хүлээн авч бүртгэх,;
 - тусгай зөвшөөрлийн бүртгэл хөтлөх;
 - тусгай зөвшөөрлийн зураг зүйн бүртгэл хөтлөх;
 - түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;
 - үйлчилгээний хөлс, түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хураан авах;
 - тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд гарсан хилийн маргааныг хянан шийдвэрлэх;
 - сонирхсон этгээдэд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй танилцах бололцоо олгох, эдгээр бүртгэлд орсон өөрчлөлтийн талаар зохих байгууллагад мэдэгдэж нийтэд мэдээлэх.
 - энэ хуулийн 12.1.5-д заасны дагуу сум, дүүргийн Засаг даргын гаргасан хүсэлтийг хүлээн авч сонгосон газар нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох.
 - хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргасан хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн мэдээллийн бүртгэл хөтлөх;
 - энэ хуулийн дагуу ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалтын талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН БҮТЭЦ





САЛБАРЫН БОДЛОГО,
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН



ТӨРИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

- **Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /2014-2025/, УИХ-ын 2014.01.16-ны өдрийн 18 дугаар тогтоол** (Хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино)
 - I үе шат /2014-2015 он, Эрх зүйн орчныг сайжруулж, холбогдох дүрэм, журам, хөтөлбөр, төслийг боловсруулах/
 - II үе шат /2020-2025 он, Хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх/
 - III үе шат /2020, 2025 он, Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хэрэгжилтийн дунд шатны тайланг дүгнэж, цаашдын зорилтын хэрэгжилтийг хангах/
- **Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого /2018-2027/, ЗГ-ын 2018.06.06-ны өдрийн 169 дугаар тогтоол** (Монгол Улсын газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангахад оршино)
 - I үе шат /2018-2021 он, Бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож, дэд бүтцийг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой газрын тосны компанийг байгуулах ажлыг эхлүүлснээр улсын нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадвар дээшилнэ./
 - II үе шат /2022-2027 он, Стратегийн ач холбогдол бүхий газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажил эрчимжиж, газрын тосны нөөц, олборлолт нэмэгдэн боловсруулах үйлдвэр байгуулагдаж, хүний нөөцийн чадавх бэхжиж, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурь бий болно/



ТӨРИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

- **Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, УИХ-ын 2015.06.19-ний өдрийн 62 дугаар тогтоол /2015-2030/** (Бодлогын зорилго нь дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн салбарыг Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд оршино)
 - I үе шат /2015-2020 он, Үндэсний үйлдвэрлэлийг хамгаалж, үндсэн түүхий эдийг дотооддоо боловсруулж, техник, технологийг нутагшуулан экспортыг дэмжих, импортыг орлох аж үйлдвэрийн бодлогыг хэрэгжүүлнэ/
 - II үе шат /2020-2025 он, Экспорт давамгайлсан аж үйлдвэрийн бүтцийг бий болгож өндөр технологи, машин, тоног төхөөрөмж, химийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ./
 - III үе шат /2025-2030 он, мэдлэгт суурилсан аж үйлдвэрийг хөгжүүлж, үйлчилгээ болон технологийн экспортыг дэмжин хөгжүүлнэ/
- **“Алт-2” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017.01.18-ны өдрийн 20 дугаар тогтоол** (Монгол Улсын алтны үйлдвэрлэлийн ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж алт олборлох, боловсруулах үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи, менежмент нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн үр дүнг сайжруулах, алтны үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн чадавхийг өсгөхөд энэхүү үндэсний хөтөлбөрийн гол зорилго оршино)
 - I үе шат /2017-2018 он, Алтны үйлдвэрлэлтэй холбоотой харилцаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, геологийн судалгаа, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлснээр алтны олборлолтыг нэмэгдүүлэх, бэлтгэгдсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг цэгцлэх ажлыг эхлүүлнэ/
 - II үе шат /2019-2020 он, Алтны эрэл хайгуул хийх болон олборлох, үйлдвэрлэхэд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж алтны олборлолт, үйлдвэрлэлийг тогтвортой өсгөх, байгаль орчин, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ/



- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэнэ.
- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилго нь хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацыг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино.
- Эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим
 - Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор эрх зүй, татварын орчны талаар аливаа шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээнд суурилж, оролцогч талуудын хууль ёсны эрх ашгийг хохироохгүй байх;
 - Олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэт техник, технологи, инновацыг дэмжих;
 - Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж нээлттэй, ил тод, хариуцлагатай байх;
 - Эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулагч нь хууль дээдлэх, харилцан ашигтай ажиллах, компанийн сайн засаглалыг дэмжих;
 - Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төрөөс хөрөнгө оруулагчдад ижил тэнцүү нөхцөл олгож, өмчийн хэлбэрээр ялгаварлахгүй байх;
 - Улсын болон хувийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байгаа бүх шатны геологийн судалгаа, олборлолт, боловсруулалтын ажлын талаарх хуулиар хориглоогүй мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй байлгах;
 - Эрдэс баялгийн салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, стандартыг олон улсын түвшинд хүргэж, хэрэгжилтийг хангах;
 - Төрийн зохицуулалтыг бүртгэл, зөвшөөрөл, хяналтын түвшинд төгөлдөржүүлж, ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд оролцохыг зохистой түвшинд байлгах.

САЛБАРЫН ХУУЛЬ

- ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ (1988)
- АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ (1994, 1997, 2006, 2014)
- ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ (2014)
- ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬ (2009)
- ГОЛ МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСАН САНГИЙН ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬ
- ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ
- ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬ 2014
- ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬ 2005



ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016-2020 ОНЫ ХӨТӨЛБӨР

▪ ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, арилжих, эргэлтэд оруулах замаар иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааг үнэ цэнэтэй болгоно.
- Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэт зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлнэ.

▪ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ, ОЛОН УЛСЫН ЭРДСИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ.

- Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ.
- Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.
- Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.
- Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.
- Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө.
- “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.



ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2016-2020 ОНЫ ХӨТӨЛБӨР

- ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ, ОЛОН УЛСЫН ЭРДСИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ.
 - Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна.
 - Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгоно.
 - Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ.
 - “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Монголбанктай хамтран шийдвэрлэнэ.
 - Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
 - Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.
 - Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.
 - Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
 - Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.
 - Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.
 - Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2020 ОН ХҮРТЭЛ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ


- ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
- ЭРДЭС БАЯЛГИЙН БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ
- ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
- ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА
- АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
- ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
- ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
- УУРХАЙН ХААЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ –УУЛ УУРХАЙН ТУХАЙ ХУУЛЬ
- ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ



ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН САЛБАР




ГЕОЛОГИЙН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ



Монгол Улсын нутаг дэвсгэрийн 40 орчим хувь нь 1:50000 масштабтай геологийн зураглалд хамрагдаад байна.

ГЕОЛОГИЙН СУДАЛГАА, ЭРЭЛ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮН



80-аад төрлийн ашигт малтмалын 1200 гаруй орд, 10000 гаруй илэрцийг тогтоогоод байна

ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТҮВШИН, ҮР ДҮН

Геологийн ажлууд	
1:200 000 геологийн зураглал	100%
1:200 000 агаарын сорозон зураглал	60%
1:200 000 хүндийн хүчний зураглал	22%
1:50 000 геологийн зураглал	33.7%
Гидрогеологийн зураглал	84%

Ашигт малтмал	Хэмжих нэгж	Нөөц баялаг
Зэс	сая тн.	57
Нүүрс	тэрбум тн.	175.5
Төмрийн хүдэр	тэрбум тн.	1.2
Алт	тн.	2500
Цайр	сая тн.	1.7
Хайлуур жонш	сая тн.	3.8
Уран	мян.тн.	170
Газрын тос	сая тн.	332.6



Геологи, хайгуулын салбар өнөөдөр:

Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгодог.

Хайгуулын ажлыг хувийн хөрөнгөөр гүйцэтгэж байна.

Хүчин төгөлдөр хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо: 1301

Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ: 6734.1 мянган Га.

Нийт нутаг дэвсгэрт эзлэх хэмжээ: 4.3%

Баян-Өлгий: хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо -37, -154.7 мянган Га, -3.4%

Говь-Алтай: хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо -105, -750.0 мянган Га, -5.3%

Завхан: хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо -49, -292.1 мянган Га, -3.5%

Увс: хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо -93, -420.9 мянган Га, -6.0%


Ховд: хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо -82, -303.3 мянган Га, -4.0%



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТГЭЖ БУЙ ГЕОЛОГИЙН СУДАЛГАА

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2019 ОНД ШИНЭЭР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛУУД





УУЛ УУРХАЙН САЛБАР



Уул уурхайн салбар өнөөдөр:

Ашиглалтын тусгай зөвшөөрлийг хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч давуу эрхээр авдаг.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж эзэмшдэг.

Хүчин төгөлдөр ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо: 1682

Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ: 1656.4 мянган Га.

Нийт нутаг дэвсгэрт эзлэх хэмжээ: 1.1%

Баян-Өлгий: ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо -27, -12.9 мянган Га, -0.3%

Говь-Алтай: ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо -50, -89.1 мянган Га, -0.6%

Завхан: ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо -9, -14.1 мянган Га, -0.2%

Увс: ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо -48, -21.2 мянган Га, -0.3%

Ховд: ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо -34, -13.6 мянган Га, -0.2%



85% ЭКСПОРТ

Зэсийн баяжмал, нүүрс ,төмрийн хүдэр,
түүхий газрын тос болон бусад.



64% ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Уул уурхайн олборлолт, баяжуулалт,
хүнд үйлдвэрийн салбарт шингэдэг.



71% АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Уул уурхайн салбараас гаралтай.



20% ДНБ

Дотоодын нийт бүтээгдэхүүнд уул уурхайн
салбарын эзлэх хувь.

Монгол улсын эдийн засагт
уул уурхайн салбарын нөлөө
нэн чухал үүрэгтэй.
Энд зөвхөн шууд
нөлөөллийг харууллаа.
Үүнээс гадна шууд бус
нөлөөлөл маш их байгаа




ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР



ГАЗРЫН ТОСНЫ НӨӨЦ, ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТ

БХГ-т 32 талбай ялгаснаас: 19 компани Хайгуулын 22 талбайд хайгуулын, 2 компани 3 талбайд ашиглалтын үйл ажиллагаа тус тус явуулж байна.



ГАЗРЫН ТОСНЫ НӨӨЦ


Нөөцийн төрөл	Нөөц, сая тонн
Баталгаат	332.64
Ашиглалтын баталгаат	43.2

ШИНЭЭР АШИГЛАХ БОЛОМЖТОЙ ГАЗРЫН ТОСНЫ ОРД, ИЛРЭЛ

ТАЛБАЙ	ХӨХ НУУР-ХVІІІ	ГАЛБА-ХІ
Өрөмдсөн кооногийн тоо	4	14
Тосны илэрцтэй кооногийн тоо	2	13



Газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ /бүс нутгаар/






ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР



Хүнд үйлдвэрийн салбарын бодлого

Хөрөнгө оруулалт шаардлагатай хүнд үйлдвэрийн төслүүд



Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр

1 сая.тн/жил (Зэсийн баяжмал)
2.3 тэрбум ам.доллар

Өнөөгийн төвшин:

Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ, БОЕУ-г боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлсэн.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт 466 га газрыг төсөл хэрэгжүүлэх зориулалтаар Засгийн газрын 2018.12.12-ны өдрийн 378 дугаар “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” тогтоолоор батлуулсан



Нүүрс, кокс химийн үйлдвэр

НҮҮРСНЭЭС НИЙЛЭГ БАЙГАЛИЙН ХИЙ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСӨЛ
725 сая м3, 300 мян.тн автобензин
2.1 тэрбум ам.доллар


Өнөөгийн төвшин:

2016 оны 12 –р сард УТЭЗҮ-г хүлээн авна. 2017 оны I улиралд ТЭЗҮ (Bankable) бэлэн болно.

НҮҮРСНЭЭС НИЙЛЭГ БАЙГАЛИЙН ХИЙ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСӨЛ
50 сая м3

88.9 сая ам.доллар

МЕТАЛЛУРГИЙН КОКС, ЦЭВЭР ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭР
285 мян.тн, 232 сая ам. доллар



Төмөрлөгийн үйлдвэр


ДАРХАН-СЭЛЭНГИЙН ХАР ТӨМӨРЛӨГИЙН ЦОГЦОЛБОР
700 сая ам.доллар

Өнөөгийн төвшин:

ТЭЗҮ-ийг Дэлхийн банкны санхүүжилтээр Канад улсын “Hatch” компани гүйцэтгэсэн.

ЭРДЭНЭТИЙН ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ЦОГЦОЛБОР
79.4 сая ам.доллар

“МОНГОЛ ШИРЭМ” ТӨСӨЛ
30.25 сая ам.доллар



Газрын тос боловсруулах үйлдвэр

1.5 сая тн (түүхий тос)
1 тэрбум ам. доллар

Өнөөгийн төвшин:

- Төслийн нэгж “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийг байгуулсан

- Техник-эдийн засгийн үндэслэлийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж бэлэн болгосон.

- Үйлдвэрийн цахилгаан хангамж, авто болон төмөр замын асуудлыг шийдвэрлэсэн

- Түүхий эд тээврийн асуудлыг шийдвэрлэх



Үйлдвэрлэл, технологийн парк


БАЯНГОВЬ 10 үйлдвэр
1.55 тэрбум ам. доллар

БАГАНУУР 14 үйлдвэр
2.6 тэрбум ам.доллар

ДАРХАН 12 үйлдвэр
187.0 сая ам.доллар

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР
94.5 сая ам.доллар

Үйлдвэрлэл, технологийн парк төсөл





ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА



ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Ашигт малтмалын асуудлаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;
 - харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох;
 - байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;
 - [Газрын тухай хууль](#)-д заасан үндэслэл, журмын дагуу тодорхой газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах.
 - Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгохоор сонгосон газрын талаар энэ хуулийн 11.1.23-д заасан дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.



ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 12 ДУГААР ЗҮЙЛ. ЭД ХӨРӨНГИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ
 - 12.1.Ашигт малтмалын асуудлаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 12.1.1.ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;
 - 12.1.2.харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох;
 - 12.1.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;
 - 12.1.4.[Газрын тухай хуульд](#) заасан үндэслэл, журмын дагуу тодорхой газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах.
 - 12.1.5.Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгохоор сонгосон газрын талаар энэ хуулийн 11.1.23-д заасан дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.
- АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 41 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЭД ХӨРӨНГИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ
 - 41.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.
- АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 42 ДУГААР ЗҮЙЛ. НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРЬЦАХ
 - 42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.
 - Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор “Орон нутагтай хамтран ажиллах гэрээний загвар”-ыг баталсан.



ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 12 ДУГААР ЗҮЙЛ. ЭД ХӨРӨНГИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ
 - 12.1.Ашигт малтмалын асуудлаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 12.1.1.ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;
 - 12.1.2.харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох;
 - 12.1.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;
 - 12.1.4.[Газрын тухай хуульд](#) заасан үндэслэл, журмын дагуу тодорхой газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах.
 - 12.1.5.Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгохоор сонгосон газрын талаар энэ хуулийн 11.1.23-д заасан дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.
- АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 41 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЭД ХӨРӨНГИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ
 - 41.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.
- АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 42 ДУГААР ЗҮЙЛ. НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРЬЦАХ
 - 42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.
 - Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор “Орон нутагтай хамтран ажиллах гэрээний загвар”-ыг баталсан.



ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 43 ДУГААР ЗҮЙЛ. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ТАЛААР ТАВИГДАХ ШААРДЛАГА**
 - 43.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно.
 - 43.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.
 - 43.3.Энэ хуулийн 43.2-т заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, боловсролын болон эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаархи журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.
- **ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 60 ДУГААР ЗҮЙЛ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН**
 - 60.2.6.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь;
 - 60.2.7.ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь.
 - 60.5.Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.6-д заасан орлогын 33-аас доошгүй хувийг ашигт малтмалын олборлолт хийсэн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.
 - 60.6.Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.



ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД АНХААРАХ АСУУДАЛ

- Хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, боломжийг ашиглаж ажиллах
- Засгийн газрын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтэд анхаарч ажиллах
- Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг зохион байгуулалтад оруулах асуудалд анхаарах
- Төсвийн хөрөнгөөр судалгааны ажил гүйцэтгэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, БХГ-тэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах
- Орон нутагт геологи, уул уурхай, газрын тосны асуудал хариуцсан нэгжийг байгуулах асуудлыг шийдвэрлэх



❖ Хууль эрх зүйн орчны шинэчлэлт

❖ Дэд бүтцийн асуудал

- ❖ Зам, тээвэр
- ❖ Усан хангамж
- ❖ Цахилгаан хангамж

❖ Хүний нөөцийн хангамж

- ❖ Инженер техникийн ажилтан
- ❖ Мэргэжлийн боловсрол

❖ Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа

- ❖ Нэгдсэн зохион байгуулалтад оруулах



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА